

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТЭРГҮҮЛЭХ АЖИЛТАН, АКАДЕМИЧ ДЭЧИНГУНГААГИЙН ДОРЖГОТОВ
ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ, ТЭРГҮҮН ЗЭРГИЙН “ЧИНГИС ХААН” ОДОН
ХҮРТЛЭЭ**

**ACADEMICIAN. DORJGOTOV DECHINGUNGAA, A LEADING SCIENTIST OF THE
INSTITUTE OF THE GEOGRAPHY AND GEOECOLOGY OF THE MONGOLIAN
ACADEMY OF SCIENCES, WAS AWARDED THE SUPREME DECORATION OF THE
MONGOLIAN STATE, THE ORDER OF “CHINGGIS KHAAN”**

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн хувьд 2022 онд Газарзүй-цэвдэг судлалын хүрээлэн байгуулагдсаны 60 жил, Геоэкологийн хүрээлэн байгуулагдсаны 25 жилийн түүхэн ой тохиосны зэрэгцээ Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич Дэчингунгаагийн Доржготовт төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одон хүртээсэн нь Монгол Улсын газарзүй, хөрс судлалын шинжлэх ухааны салбарын ололт амжилтыг төр засгаас өндрөөр үнэлсэн онцгой үйл явдал боллоо.



Академич Дэчингунгаагийн Доржготов 1940 онд Төв аймгийн Авдарбаян (одоогийн Баян) сумын нутагт малчин ардын гэр бүлд төрж, 1947-1957 онд Улаанбаатар хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургуульд, 1957-1962 онд Москва хотын М.В.Ломоносовын нэрэмжит Улсын Их Сургуульд тус тус суралцаж төгссөн ба хөрс судлаач-агрохимич эрдэмтэн хүн юм.

Д.Доржготов 1962 оноос өнөөдрийг хүртэл ШУА-ийн Газарзүйн (одоогийн Газарзүй, геоэкологийн) хүрээлэнд 60 жил тасралтгүй ажиллахдаа 1962-1974 онд эрдэм шинжилгээний ажилтан, 1974-1994 онд хөрс-геохимийн тасгийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, 1994-2014 онд Газарзүйн хүрээлэнгийн захирал, 2014 оноос хойш эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар ажиллаж ирсэн.

Д.Доржготов нь 1973 онд Москва хотноо Оросын ШУА-ийн Газарзүйн хүрээлэнд газарзүйн ухааны дэд эрдэмтний (Ph.D), 1992 онд Москва хотын М.В.Ломоносовын нэрэмжит Улсын Их Сургуулийн Хөрс судлалын факультетад биологийн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг тус тус хамгаалж, 1998 онд Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн-академичаар сонгогдож, улмаар 2002 онд МУБИС-ийн профессор, 2010 онд Монгол Улсын Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн академич цол, 2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Академич” хэргэм хүртжээ.

Тэрээр өнгөрсөн хугацаанд Монгол орны хөрс, газарзүй, байгаль орчин, экологийн чиглэлээр эрдэм шинжилгээний 30 гаруй сэдэв, төсөл, грант судалгааны ажил удирдан гүйцэтгэж, дотоод, гадаадын

эрдэмтэн, судлаачдын хамт эх орны ихэнх нутгийг хамарсан 50 гаруй удаагийн хээрийн экспедиц зохион байгуулж, эрдэм шинжилгээний 310 гаруй бүтээл туурвиж, түүнээс 110 гаруйг нь орос, англи, герман, хятад хэл дээр хэвлэн нийтлүүлсэн байна. Нэрт эрдэмтний олон жилийн эрдэм шинжилгээний ажлын үр дүн, ач холбогдлыг дараах долоон чиглэлээр төрөлжүүлэн тодорхойлж байна.

Нэгдүгээрт, Монгол орны хөрсний гарал үүсэл, газарзүй, ангилал, үндсэн шинж чанар, үржил шим, чанарын үнэлгээ зэрэг онолын суурь судалгаанд төвлөрөн ажиллаж, “Основные черты географии почв Северной Монголии и характеристика степных почв” (Москва, 1973), “Монгол орны хөрс-газарзүйн мужлалт” (УБ,1976), “Сэлэнгийн сав газрын хөрс” (УБ,1980), “Почвенный покров и почвы Монголии” (Москва, 1984), “БНМАУ-ын байгалийн үнэлгээ: хөдөө аж ахуйд зориулсан” (УБ,1984), “БНМАУ-ын хөрсний ангилал зүй” (УБ, 1986), “Почвы Монголии: генезис, систематика, география, ресурсы и использование” (Москва, 1992), “Состояние почв богарных пашен Монголии и методические рекомендации по его оценке” (Москва, 1990), “Монгол орны хөрс” (УБ, 2003) зэрэг онол-практикийн чухал ач холбогдол бүхий томоохон ганц сэдэвт ном бүтээлүүд (монограф) туурвижээ.

Хоёрдугаарт, хөрсний суурь судалгааны үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хөрсний зураглалын ажлыг эх орондоо анх удаа системтэйгээр эхлүүлж, Монгол орны хөрсний 1:2 500 000 масштабтай анхны ханын зургийг 1975 онд зохиож хэвлүүлсэн байна. Оросын эрдэмтэн судлаачидтай хамтран манай орны хөрсний 1:2 500 000, 1:3 000 000 масштабтай зургуудыг шинэчлэн боловсруулж (1980, 1990), нийтийн хүртээл болгожээ. Мөн сансрын зураг ашиглан анх удаа Монгол орны хөрсний 1: 1 000 000 масштабтай зураг үйлдэж (1981), уг зураг дээр манай оронд судлагдсан бүх хэв шинж, дэд хэв шинжийн хөрс, тэдгээрийн орон зайн бүтцийг илэрхийлсэн хөрсний 220 гаруй ялгаврын тархалтыг дүрслэн харуулсан нь зурагзүйн үнэ цэнтэй ховор бүтээл болсон төдийгүй энэ зургийг ашиглан Монгол орны бүх төрлийн хөрсний нөөцийг тооцоолон гаргах боломжийг бүрдүүлжээ. Эдгээрээс гадна Монгол орны хөрсний жижиг масштабын олон зураг зохиосон нь хөрсний тухай шинжлэх ухаанч мэдлэг, мэдээллийг олон түмэнд хүргэсэн танин мэдэхүйн цогц ажил болсон юм. Сургалтад зориулж Монгол орны хөрсний 1:2 500 000, 1:1 500 000 масштабтай зургууд зохиосон нь (2002, 2006) эдүгээ нэгэнт сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болж, үе үеийн сурагч, оюутнуудын мэдлэгийн санд хувь нэмэр оруулсаар байгаа болно.

Гуравдугаарт, Монгол Улс “Үндэсний атлас”-тай болох нийгэм-эдийн засаг, шинжлэх ухааны үндэслэл, хэрэгцээ шаардлагыг холбогдох байгууллагуудад дэвшүүлэн тавьж, санаачлан хөөцөлдсөний үр дүнд 16 сэдэвчилсэн бүлэг бүхий, 1: 3 000 000, 1: 4 500 000, 1:6 000 000, 1:9 000 000, 1:12 000 000 масштабын 300 гаруй газрын зураг, схемийг багтаасан “БНМАУ-ын Үндэсний атлас” хэмээх суурь том бүтээлийг 1990 онд орос, монгол хэл дээр хэвлүүлсэн байна. 300 шахам эрдэмтэн мэргэжилтнүүдийн мэдлэг, хөдөлмөр шингэсэн Үндэсний атлас зохиох шинжлэх ухааны редакцын зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллахын зэрэгцээ Хөрсний бүлгийн зураг, тайлбарыг хамтран зохиож, уг атласт орсон бүх зургийн тайлал, сэдэвчилсэн бүлэг тус бүрийн тайлбар өгүүллийг орос, монгол хэл дээр нийцүүлэн редакторлаж, хэвлэлд шилжүүлэх нөр их ажлыг гардан гүйцэтгэсэн байна. Монгол Улсын анхны Үндэсний атлас зохиосон туршлага дээрээ тулгуурлан тэрбээр 2009 онд “Монгол Улсын Үндэсний атлас”-ын Ерөнхий редактораар ажиллаж, дахин шинэчлэн зохиож хэвлүүлсэн юм. Монгол Улсын Үндэсний атлас нь 120 гаруй эрдэмтэн судлаачдын зохиосон 1:2 000 000, 1: 5 000 000, 1: 10 000 000, 1:12 000 000, 1:15 000 000 масштабтай 256 ширхэг газрын зургийг багтааж, манай эх орны нутаг дэвсгэр, засаг захиргааны бүтэц, байгаль-газарзүйн нөхцөл, нийгэм, эдийн засгийн олон талт мэдээллийг шингээсний хувьд шинжлэх ухаан –лавлагааны цогц эх сурвалж төдийгүй, эрдэм шинжилгээ, танин мэдэхүй, онол, практикийн өндөр ач холбогдол бүхий иж бүрэн агуулгатай зурагзүйн суурь бүтээл, бодлого боловсруулагчдын ширээний ном юм.

Дөрөвдүгээрт, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, бохирдол, экосистемүүдийн тэнцвэрийн алдагдал, экологи-геохимийн төлөв байдал нь хүн төрөлхтний тулгамдсан асуудал болоод байгаа өнөө үед академич Д.Доржготовын удирдсан судалгааны баг “Улаанбаатар хотын байгаль орчны (экосистемийн) судалгаа, бохирдлын тойм зураглал” (1999), “Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн хөрсний бохирдлын судалгаа” (2003), “Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрүүдийн орчмын хөрсний бохирдлын судалгаа” (2004), “Дархан хот орчмын геоэкологийн судалгаа” (2009), “Хөрс бохирдуулагч бодисуудын (химийн элементүүдийн) зөвшөөрөгдөх дээд хэмжээний улсын стандарт” (2008), “Улаанбаатар хот орчмын хөрсний бохирдлын судалгаа” (2010), “Сэлэнгийн сав нутаг дахь уул уурхай, аж үйлдвэрийн томоохон төвүүдийн байгаль орчин, экогеохимийн судалгаа” (2015) зэрэг ажлуудыг

гүйцэтгэж, үр дүнгийн тайлан, технологийн шийдэл, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад шилжүүлжээ. Түүнчлэн Оросын эрдэмтэн судлаачидтай хамтарсан “Монгол орны экосистемийн зураг, атлас” (1995, 2005), “Байгал нуурын сав газрын экологийн атлас” (2015), “Сэлэнгэ-Байгаль нуур” сэдэвт экологи-газарзүйн атлас – нэг сэдэвт ном (2018), “Монгол орны экосистемийн атлас” (2019), “Байгаль нуурын бүс нутгийн атлас” (2021), зэрэг томоохон бүтээлүүд нь эх орны төдийгүй бүс нутгийн экологи, эко-геохими, экосистем, байгаль орчны салбарын шинжлэх ухааны хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж, практик хэрэглээнд чиглэсэн, шинэлэг, дорвитой, суурь өгөгдлөөр баялаг ажил болсон байна.

Тавдугаарт, академич Д.Доржготов нь шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх, олон түмний танин мэдэхүйн хэрэгцээг хангах үйлсэд олон арван жил нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэж, “Монголын нэвтэрхий толь”, 2 боть (2000), “Монголын цагаан ном” (2002), “Монгол Улсын Үндэсний нэвтэрхий толь” 3 боть (2009), “Монголын байгаль орчны нэвтэрхий толь” (2013), “Монголчуудын түүх, соёлын атлас” (2004), “Монгол улсын газарзүйн атлас” (2004), Өвөр Монголын Багшийн Их сургуулиас хэвлүүлсэн “Монгол судлалын нэвтэрхий толь, Газарзүйн боть” (2012), зэрэг томоохон бүтээлүүдийн редактор, хамтран зохиогчоор ажиллаж ирсэн байна.

Зургадугаарт, Академич Д.Доржготов шинжлэх ухааны салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар өндөр идэвх санаачилгатай ажиллаж, Орос, Герман, Хятад, Польш, Япон, Солонгос, Унгар, Казахстан, Итали, Америк зэрэг улсын эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулж, Орос, Герман, Хятад, Япон, Польшийн эрдэмтэн судлаачидтай хамтарсан хээрийн экспедиц, суурин судалгааны газар ажиллуулж, “Зүүн хойд Азийн байгаль орчны өөрчлөлт” Монгол-Солонгосын эрдэм шинжилгээний семинар, хээрийн экскурсийг 9 удаа, “Монголын тэгш өндөрлөг ба зэргэлдээх нутгийн байгаль орчин, тогтвортой хөгжил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 13 удаа зохион байгуулсан байна. Энэ нь шинжлэх ухааны олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, улс орнуудын эрдэмтэн судлаачид, багш, оюутнуудын харилцан уялдаатай хамтын ажиллагааг төлөвшүүлэх, эрдэм шинжилгээний гадаад харилцааг шинэ түвшинд гаргахад бодит түлхэц болсон юм. Тэрбээр дэлхийн хэмжээний эрдэмтэний хувьд олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд 60 гаруй удаа биечлэн оролцож, илтгэл тавьж, санал бодлоо илэрхийлж байсан нь манай үе үеийн судлаачдын гадаад хамтын ажиллагаанд чухал хувь нэмэр оруулсан билээ.

Долдугаарт, академич Д.Доржготов шинжлэх ухааны боловсон хүчин бэлтгэх, сурган хүмүүжүүлэх үйл хэрэгт хичээнгүйлэн зүтгэж, 1978 оноос эхлэн МУИС, МУБИС-ийн газарзүйн тэнхимүүдэд хичээл зааж, улмаар 1998 оноос МУИС-ийн Газарзүйн салбарт профессор багш, 2004-2008 онд Геоэкологи-газрын менежментийн тэнхимийн эрхлэгч, 2008-2013 онд Геоэкологи-орчин судлалын тэнхимийн эрхлэгч, 2013-2018 онд зөвлөх багшаар тус тус ажиллаж, дээд боловсролын салбарт нийт 40 жил хүчин зүтгэсэн байна. Энэ хугацаанд 20 хүний доктор (Ph.D)-ын, 3 хүний шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын судалгааны ажлыг удирдан хамгаалуулжээ. Түүнчлэн докторын (Ph.D) ба шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалсан дотоод, гадаадын 52 хүний диссертацийн ажилд санал шүүмж бичсэн байна. Ийнхүү тэрээр Газарзүй, Хөрс судлал, Геоэкологи, Орчин судлалын шинжлэх ухааны салбарын эрдэмтдийн залгамж халааг бэлтгэх, нарийн мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцийг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсаар иржээ.

Д.Доржготов нь 1975 оноос өнөөг хүртэл Газарзүйн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга, орлогч дарга, даргаар тасралтгүй ажиллаж, энэ хугацаанд 110 гаруй хүний эрдмийн зэрэг (Ph.D) хамгаалах хуралд биечлэн оролцож, мэргэжлийн үүднээс санал дүгнэлт өгсөн байна. Мөн тэрээр 2000 оноос ШУА-ийн дэргэдэх Геологи-газарзүйн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалуулах зөвлөлийн орлогч дарга, даргаар, 2018 оноос ШУА-ийн дэргэдэх Газар тариалан-ургамал хамгааллын шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

Академич Д.Доржготов 1974 оноос одоо хүртэл ШУА-ийн Газарзүйн (2017 оноос Газарзүй-Геоэкологийн) хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн гишүүн, 1994-2014 онд хүрээлэнгийн захирал, 1994 оноос одоо хүртэл Монголын Газарзүйн нийгэмлэгийн тэргүүн, 1997 оноос одоо хүртэл ШУА-ийн Геологи-Газарзүйн салбарын бага чуулганы орлогч дарга, даргаар, 2001-2009, 2016-2020 онуудад ШУА-ийн тэргүүлэгч гишүүн, 2002-2010 онд Монгол Улсын Засгийн Газрын дэргэдэх Шинжлэх Ухаан Технологийн Үндэсний Зөвлөлийн гишүүн, 2004-2008 онд БОАЖЯ-ны ШУТЗөвлөлийн гишүүн, 2006-2010 онд Цөлжилттэй тэмцэх Үндэсний Хорооны гишүүн зэрэг ажил үүргүүдийг нэр төртэй хашиж,

шинжлэх ухааны салбарын бодлого шийдвэр гаргах, удирдан зохион байгуулах ажилд идэвх санаачилгатай оролцож байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Академич Д.Доржготовын Шинжлэх ухааны салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан гавьяа зүтгэлийг төр засгаас өндөр үнэлж “Алтан гадас” одон (1995), “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” (2001), Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цол (2009), “МУ-ын Боловсролын тэргүүний ажилтан” (2006), “МУ-ын Байгаль орчны тэргүүний ажилтан” (2006), Монгол Улсын Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” (1996) цолоор шагнажээ. Мөн “Багшийн гавьяа” одон (2011), “Тусгаар тогтнол” одон (2012), Монгол Улсын ШУА-ын дээд шагнал “Хубилай хаан” алтан медаль (2010), Шинжлэх Ухааны шилдэг бүтээлийн шагналаар гурван удаа (2004, 2009, 2015) шагнагдсан байна. Мөн “Ардын хувьсгалын 60, 70, 80 жилийн ойн медаль”, “Боловсрол-90” медаль, “Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой медаль”, “Оросын Шинжлэх Ухааны Академийн хүндэт жуух” (2010), Оросын Газарзүйн нийгэмлэгийн дээд шагнал “Н.М.Пржевальскийн нэрэмжит алтан медаль” (2018) болон бусад олон шагналтай. Академич Д.Доржготов эх орондоо газарзүй, хөрс судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх үйл хэрэгт нэгэн жарны турш хүчин зүтгэж яваа энэ цаг үеийн нэрт эрдэмтэн, шинжлэх ухааны зүтгэлтэн, нэрт сурган хүмүүжүүлэгч хүн билээ.